

МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ӨМЧЛӨЛ БА ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛИЙН ТӨЛӨВШИЛ

М.Зулькафиль*

Б.Болд-Эрдэнэ**

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн тэргүүлэх профессор, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

** МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

Түлхүүр үг: ардчиллын үнэлэмж, олон нийтийн ухамсрын төлөвшил, чөлөөт хэвлэл, мэдээллийн орон зай, хариуцлагатай сэтгүүл зүй.

Бид хүний эртний, эргэлзэшгүй, төрөлх эрх болох үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, чөлөөт хэвлэлийн тулгуур зарчмыг Үндсэн хуулийнхаа зүйл заалт болгоод хорь шахам жил болжээ. Эрх чөлөөг улс орон, нийгмийнхээ оюун санааны хөгжлийн үндэс хэмээн тунхаглаад даруй нэг бүтэн үеийн иргэншлийн хугацаа өнгөрчээ.

Хорин жилийн өмнө нам төрийн эрхийг барьдаг цөөхөн хэдэн хүний үзэл бодолд нийцүүлэн нийтлэл, нэвтрүүлгийг агуулгын төдийгүй, хэлбэрийн хувьд ч цагдан хянадаг байгууллагыг татан буулган, Үндсэн хуулиар иргэдийн хамгийн чухал, язгуур эрх чөлөө болох үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулан, иргэдийн ХМХ-ийг эрхлэн гаргах үйл

ажиллагааг нээлттэй болгон, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” (1998) Монгол Улсын хууль батлагдсан нь манай оронд чөлөөт хэвлэлийн эх суурь тавигдаж, цаашид жам ёсоор хөгжих үүд хаалгаа нээж өгсөн билээ. Энэ бүхний үр дүнд сэтгүүл зүй нь нийгмийг өөрчлөн шинэчлэх, ардчиллыг хөгжүүлэх, ил тод байдал, олон ургальч үзлийн индэр болох, нөгөө талаар техник, технологи үйл ажиллагааныхаа зарчмыг олон нийтийн мэдээллийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан өөрчлөх, зах зээлийн жам ёсны хөгжлийн дагуу зохицуулах гэсэн хоёр чухал зорилтыг нэгэн зэрэг шийдвэрлэх шаардлага тулгарсан юм.

Гэвч үзэл бодол сайхан ч амьдрал өөрийнхөө хэв маяг, чанараар үргэлжилж, хориод жилийн дараа ч бүх зүйл урьдын адил хүсэл, холын хэвээрээ л байна. Өнөөдөр ч гэсэн чөлөөт хэвлэл оршин буй эсэх, ардчилсан, нээлттэй нийгмийн мөн чанар болж чадаж байгаа эсэх, хүмүүсийн амьдралд “үнэний хүчилтөрөгч” болж байгаа эсэх талаар

хэн ч тодорхой бус хариулт өгөхөөр тийм эргэлзээтэй нөхцөлд байна. Саяхан олон улсын "Freedom House" байгууллагаас гаргасан 2008 оны хэвлэлийн эрх чөлөөний байдлын тухай илтгэлд Монгол Улс "хагас эрх чөлөөтэй" буюу 195 орноос 86 дугаар байранд орж, өнгөрсөн жилээс гурван шатаар ухарчээ. Тэгээд ч өнөөдрийг хүртэл бидний дунд хүний төрөлх, нийгмийн мэдэх эрхийн тухай яриа дахин дахин өрнөсөөр л байна.

Үнэхээр чөлөөт хэвлэл жинхэнэ утгаараа оршиж, Монголын нийгэм, монголчуудын амьдралд өрнийн Дахин сэргэлтийн эринд анх томъёологдож байсан үеийнх шиг "үнэн, гэгээрэл, эрүүл оюун ухаан"-ы тулгуур багана болж чадаагүй л байна. Тэр дундаа нийгмийн хөгжил, сайн сайхны учир шалтгаан нь хүний эрх болохын үнэний орон зай бичиг цаас, тунхаг уриалгаас хэтрэхгүй л байна. Тиймээс хүн өөрийнхөөрөө байж, өөрийгөө мэдэж, өрөөлийн өмнө өөрийнх шиг эрхийн хэм хэмжээгээр хүлцэн тэвчдэг соёлыг эрхэмлэн, улмаар түүнийгээ нийгмийн дэг журмын үндсэн "гэрээ" болгон хүлээн зөвшөөрдөг ардчилсан, хөрөнгөт нийгмийн үнэлэмж төлөвшин тогтнох нь бүү хэл үгүйлэгдсээр байгаа нь бидний үнэн. Хүний бие даасан байдлыг хувийн өмчтэй байх, үзэл бодолтой байх, мэдэх эрхийн хүрээнд эрх мэдэл, төр засаглалын бүхий л төвшин, орчин хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн дэг соёлыг олон нийтийн ухамсарт төлөвшүүлэх, тэдгээрийн халдашгүй байдлыг эрхэмлэх, аливаа бүлэг, тогтолцооны хүрээнд хүлцэн тэвчихүйн хандлага байр суурийг үндэслэн, нийг-

мийн аливаа үйл явдал, үзэгдлийн тайлбар, дүгнэлт, мэдээллийн сонголтын үндэс болгох зэрэг нь мэдээллийн хэрэгсэл ардчиллын үнэлэмжийг хэрхэн төлөвшүүлж байгаагийн шалгуур болгодог билээ.

Гэтэл манай ОНМХ-ийн улс төрийн мэдээллийн үндсэн агуулга "төрөөр тэтгүүлэх, төрд бүхнийг даатгах, төр бол дэг журам, сайн сайхан бүхнийг тогтоогч, хамгаалагч", түүнгүйгээр хувь хүн өөрийн хүсэл зорилгодоо хэзээ ч хүрч чадахгүй гэсэн авторитар нийгмийн үзэл, үнэлэмжийг агуулж байгаа нь хатуу ч гэсэн бодит зүйл болоод байна. Нөгөө талаар арилжааны, эдийн засгийн сонирхол ч орчуулгын, харийн, зугаа цэнгэлийн нэвтрүүлэг, бодит бус мэдээлэл, хэт үгүйсгэл, туйлшралын нийтлэлийн орон зайг хөхиүлэн дэмжиж байгааг тэмдэглэх ёстой. Асуудал ийм байдалд хүрснийг олон хүчин зүйл, шалтгаанаар тайлбарлаж болох ч онцгой, тэргүүлэх нэгэн үндэслэлийг энд тэмдэглэмээр байна.

Энэ бол мэдээллийн хэрэгслийн тэр дундаа телевиз, Интернет зэрэг шинэ хэрэгслийн эзэмшлийн хүрээнд гарч буй төвлөрөл, техник технологийн хөрөнгө оруулалтад "тойрсон" монопольт байдал болой. Асуудлын гол үндсэн хүчин зүйлийг ийнхүү онцлох нь ч онол, практикийн ч ач холбогдолтой. Өнөөгийн бодит байдалд шууд дүгнэлт хийвэл олон нийтийн санаа иргэдийн үзэл бодолд хэвлэл мэдээллийн нөлөө чухал, "ус агаар" мэт хэрэгтэй болохын хирээр цөөн тооны хөрөнгө мөнгө, эрх мэдэл бүхий явцуу хүрээний эрх ашгийг хамгаалсан зохион байгуулалттай

мэдээллийн нэгдэл түүний үйл ажиллагаа өсөн нэмэгдсээр байгаа юм. Энэ нь мэдээллийн хэрэгслийн эзэмшлээр дамжин нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод шууд болон шууд бус байдлаар нөлөөлж буй ерөнхий төлөв, эрх ашиг сонирхлын явцуу хүрээгээр сонгогдсон цөөн тооны хүмүүсийн үзэл бодол тайлбарыг тасралтгүй давтах ухуулгын гэмээр эргүүлэг эрчимжин байгаа, өрнөдийн нийгмийн үнэлэмж, үндэстэн дамжсан корпорациудын хэрэглэгчдийн зан төлөвийг төлөвшүүлэх зорилготой олон ангит кино, зугаа цэнгэлийн нэвтрүүлгийн орчуулгын үер нийгмийн оюун ухааныг эзэмдэж байгаа жишээ, тайлбараар нотолж болно.

Судалгааны дүн тоо баримтаар бол 2009 онд арван жилийн өмнөхтэй харьцуулбал өдөр тутмын сонины тоо таваас арван тав болж, нийслэлд нэвтрүүлгээ цацдаг телевиз даруй 13-аар өсчээ. Ерөнхий төлөв байдлыг үзсэн ч 1990-2001 онд сонины, 2001 оноос радио, 2004 оноос телевизийн тоон өсөлтийн үе байжээ¹. Энд нэг талаас мэдээллийн хэрэгслийн тоо нь чанарын буюу хөрөнгө оруулалт техник, технологийн талаас өсөн нэмэгдэж байгаа ч нөгөө талаас бодвол мөнгө санхүү, эрх мэдэл бүхий явцуу хүрээнийхний мэдээллийн орон зайд ноёрхох боломж нэмэгдсээр байгааг

логик утгаар дүгнэж болно. Үнэхээр ч олон нийтийн дуу хоолойг харьцангуй өргөн хүрээнд хүргэдэг, тэдний оюун санаа, үзэл бодлын индэр хэмээгддэг басхүү үнэ хямд хэрэгсэл болох "сонин хэвлэлийн өсөлтийн үе" 1990-2000 онд чөлөөт, бие даасан хэвлэл, мэдээллийн эрх чөлөө илүү бодитой байсан дүр зураг бий. Энэхүү дүгнэлтийг шинээр

бий болж буй телевизүүдийн ард ямар нэг бизнесмен, эсвэл гадаадын хөрөнгө оруулагч байгаагаар нотолж болох бөгөөд цаашид ч ийм хандлага улам хүчтэй өрнөх төлөвтэй байна. Ийм олон телевиз сэтгүүлчдийн хэллэгээр "борооны дараах мөөг шиг" олширч буй нь нэг талаар олон нийтийг мэдээллээр

«

*Чөлөөт хэвлэл эжинхэнэ утгаараа
оршиж, Монголын нийгэм,
монголчуудын амьдралд өрнийн
Дахин сэргэлтийн эринд анх
томьёологдож байсан үеийнх шиг
"үнэн, гэгээрэл, эрүүл оюун ухаан"-
ы тулгуур багана болж чадаагүй л
байна. Тэр дундаа нийгмийн
хөгжил, сайн сайхны учир
шалтгаан нь хүний эрх болохын
үнэний орон зай бичиг цаас, тунхаг
уриалгаас хэтрэхгүй л байна.*

»

шуурхай хангах, танин мэдэхүйн хүрээг өргөжүүлэх, нийгэмшүүлэх боломжийг нэмэгдүүлэх, телевизүүдийн хооронд үзэгчдийн төлөө, чанартай сайн нэвтрүүлгийн төлөө өрсөлдөөн бий болж сэтгүүлчид бүтээлч эрэл хайгуул хийж, идэвх санаачлагаа дээшлүүлэх, реклам захиалагчдад шинэ боломж нээх, зар сурталчилгааны орон зайг өргөтгөх, залуу сэтгүүлчдийг ажлын байраар хангах зэрэг эерэг талтай гэдэг нь ойлгомжтой юм. Нөгөө талаар, телевиз бүр улиг болсон хэдэн сэдвийн хүрээнд эргэлдэж, нэг нь нөгөөгөө давтаж, шинэ

зүйл сэтгэж, өөрийн гэсэн өнгө аястай нэвтрүүлэг бэлтгэхийн оронд гадаад, дотоодын нэвтрүүлгийг дуурайсан, эсхүл тэр чигээр нь хуулбарласан, сэдвийн болон газар зүйн хүрээ явцуу, нийгмийн давхаргын тодорхой бүлэг хэсэгт (хүүхэд залуучууд, ахмад настнууд, эмэгтэйчүүд г.м.) зориулсан гэрэлтэй гэгээтэй нэвтрүүлэг үгүйлэгдэх, залуучуудын сэтгэхүй, сонирхлоор тоглож цаг нөгцөөсөн асуудлын хүрээнд эргэлдэж, хов живийн шинжтэй, үнэн мөн нь батлагдаагүй баримт мэдээллийн араас хэт хөөцөлдөж, сэтгүүлчид өөрсдийн үзэл бодлыг бусдад тулган хүлээлгэхийг оролдсон, мэдэмхийрсэн, арилжааны шинж хэт давамгайлсан, алс ирээдүйг бус өнөө маргаашийг бодож амиа аргацаасан, бусдаас ялгарах өөрийн гэсэн өнгө аяс, өвөрмөц онцлогоо олж чадаагүй, нэвтрүүлгийн бодлого нь тодорхой бус, шууд нэвтрүүлэг, ток-шоу, далд рекламн хэдхэн төрлөөр хязгаарлагдсан шинжтэй байгаа нь туйлын харамсалтай. Бид урьд киноны дунд реклам үздэг байсан бол одоо рекламн дунд кино үзэж, мэдээ сонсдог боллоо. Хатуухан хэлбэл шинэ телевизүүд мэдээллийн хэрэгслийн биш PR-ын, хэсэг бүлэг улс төрчдийн, бизнесменүүдийн сурталчилгааны хэрэгслийн үүргийг гүйцэтгэж, тэдний үзэл бодол, дуу хоолойн индэр болж хувирсан нь хэнд ч тодорхой байна. Энд ОУСХ-ны сэтгүүлчдэд зориулсан нэгэн гарын авлагад: “Хэвлэл мэдээлэл гэдэг бизнес боловч дан ганц бизнес биш юм. Сэтгүүлч бүхэн нийгмийн өмнө хариуцлага хүлээдэг. Учир нь сэтгүүлчид зах зээл, ардчилал хоёрын торгон зааг дээр ажилладаг”², “хэвлэл

мэдээллээр гарсан ердийн мэдээ, өгүүлэл тайлбар, ярилцлага зэргийг хүмүүс реклам сурталчилгаанаас илүү итгэж хүлээн авдаг. Гэтэл далд сурталчилгаа нь энэхүү итгэлийг ашиглан олон нийтийг төөрөгдүүлж, хууран мэхэлж байгаа хэрэг юм”³ гэж онцлон тэмдэглэснийг зориуд сануулахыг хүсч байна.

Бидний 20 жилийн өмнө хэвлэл мэдээллийн эрх чөлөөг Үндсэн хуульдаа тунхаглан, нийгмийн эрүүл, зүй зохист бие даасан тогтолцоо болгох үйл хэргийг нэгэн зорилго болгож байсан нь ердөө түүх болон үлдэх аюул бодитой болж байна. **Бид хэвлэл мэдээллийн хэрэгслийг бус харин эзэд, эзэмшигчдийг эрх чөлөөтэй болгож, тэдний эрх ашиг, сонирхлыг нийгмийн оюун санаанд ямар ч хяналт шүүлтүүр үгүйгээр “туйлын үнэн” болон нэвчих боломжийг бий болгосон гэсэн үг.** Нэн ялангуяа орчин үеийн мэдээллийн орон зай “телевиз төвт Интернетийн орчин” болж байгаа гэсэн дэлхий дахины ерөнхий чиг хандлагыг эш үндэс болговол томоохон бизнес санхүүгийн нөлөө оролцооны өсөлт нь ирээдүйд болох мэдээллийн эрх чөлөөний аюулын харангын дохио болох нь тодорхой. Өнөөдөр эхлэл төдий мэт байгаа ч дэлхий дахины ерөнхий төлөв байдлаар нэгэнт тодорхой болсон томоохон бизнес санхүүгийн бүлэглэлийг тойрсон мэдээллийн монополь нь гарцаагүй олон нийтийн үзэл бодол эрх ашгийн индэр дуу хоолойг хязгаарлагч мөн. Тэгээд ч техник технологи хөрөнгө оруулалт, томоохон төсөл зэрэг мөнгө санхүүгийн бүлэглэлүүдээс шууд хамаарах хүчин

зүйлийн хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслийн ирээдүйн өрсөлдөөн, байр суурь шалтгаалах болоод байгаа билээ. Мэдээллийн технологи, холбоо харилцааны хөгжил эрс өөрчлөлт нь нийгэм хүмүүсийн ахуй амьдрал, үнэлэмж, оюун санаанд улам бүр нөлөөлөх хэтийн төлөв ч өрнөдийн судлаач эрдэмтдийн анхаарал, онцгой тэмдэглэл болсоор байна. Бүр 1947 онд Роберт Хатчинсийн толгойлсон судлаачдын гаргасан “Хэвлэлийн чөлөөт байдал ба хариуцлагын тухай” илтгэлд “шинэ технологийн хэрэглээг дагасан үйлдвэрлэлийн давуу тал нь мэдээлэл харилцааны төвлөрөл монопольт байдлын үндсэн шалтгаан болж байна”⁴ хэмээн тэмдэглэсэн нь бий. Мөн мэдээллийн нийгмийн тэргүүлэх онолч Герберт Шиллер “...үндэстэн дамжсан томоохон компаниудын дэлхийн зах зээлд нөлөө бүхий байр суурийг эзлэх, тийм боломжийг бий болгоход ... өрнөдийн томоохон мэдээллийн үйлдвэрлэгчид юуны өмнө технологийн давуу талаа хадгалж ... улмаар дэлхийн мэдээллийн шинэ орон зай дэг журмыг тогтоож байна”⁵ гэжээ. Ийм үг үзлийг Юрген Хабермасын ХХ зуунд мэдээллийн хэрэгслийн технологи, хөрөнгө оруулалтад үндэслэн нэгдсэн монопольт байдал нь нийгмийг үнэн бодит мэдээллээр хангах “үндсэн, чухал үүргийг улам бүр бүрхэгдүүлж байна”⁶ гэдэг ч юм уу эсвэл судлаач Кришан Кумарын “төр эсвэл арилжааны зорилго гэсэн хоёрхон туйлд дэлхийн мэдээллийн тогтолцооны ерөнхий дүр зураг тодорхойлогдож байна”⁷ гэсэн дүгнэлтээс харж болно.

Үнэхээр ч 2000 оноос хойш дэлхийн мэдээллийн орон зайг “Женерал Элект-

рик” (үндэсний телевизийн NBC сүлжээ), Р.Мэрдокийн “News International”, “Time Warner AOL” зэрэг цөөн тооны телевиз, радио, сонин, Интернетийн сүлжээг нэгтгэсэн “аварга нэгдэл”-үүд эзэгнэх болсон. Энэ бол дэлхий дахины үйл явц, тулгамдсан асуудал, мэдээллийн эрх чөлөөний аюулын шалтгаан. Харин Монгол бол өөр хэрэг. Мэдээж манайд хүчирхэг, томоохон мэдээллийн хэрэгслийн корпораци, “аварга нэгдэл” хараахан бий болоогүй байгаа.

Гэхдээ хүн ам цөөн, эдийн засгийн хувьд хоцрогдонгуй дэд бүтэц сул хөгжсөн, нийгмийн бүлэг төлөвшөөгүй олон нийтэжсэн улс орны хувьд нэг телевиз, нэг өдөр тутмын сонин гэдэг нөлөөллийн утгаараа “аварга сүлжээ” гэсэн үг. Тэр бүү хэл нэг нийтлэл, эсвэл нэвтрүүлэг олон нийтийн санаа бодлыг эрс өөрчлөх тийм эмзэг, өнгөн, суурь нийгмийн үнэлэмж хүмүүсийн ухамсарт бодитой байна гэхэд хилсдэхгүй. Үүний нэгэн тодорхой жишээ гэхэд л сонгуулийн өмнөх тэтгэмж мөнгөний амлалтаар сонгогчдын санал байр суурийг өөрчилж ирсэн УИХ-ын сүүлийн хоёр сонгуулийг хэлж болно.

Өөрөөр хэлбэл бие хүний өөрийгөө дээдлэх, үзэл бодол, эрх ашгаа эрхэмлэх үнэлэмж бидэнд сул бага байна гэсэн. Ийм байдалд хүргэхэд мэдээллийн хэрэгслийн агуулга, дүгнэлт тайлбарын нэлэнхүй хувийг эзэлж байгаа “төр бүхнийг шийдэх ёстой, шийдэж байна, шийдэх болно” гэсэн үзэл гол шалтгаан болж байна. Мэдээж энэхүү үзэл суртлын өнгөлөн далдлалт, чимэг “их завсарлага” болж байгаа орчуулгын зугаа цэнгэлийн нэвтрүүлэг, олон анги

кино, бараа бүтээгдэхүүний реклам сурталчилгааны хувь хэмжээ ч багагүй байгаа.

Төрийг дээдлэх явцуу хүрээнийхний эрх ашгийг хамгаалагч мэдээллийн хэрэгслүүдийн өөр хоорондын өрсөлдөөн хийгээд зөрчил нь ардчиллын үнэлэмжийг үнэгүйдүүлэх, саармагжуулах гол хүчин зүйл болж байхад үндэстэн дамжсан дэлхийн корпорацийн мэдээллийн довтолгоо болох кино, зугаа цэнгэлийн нэвтрүүлэг реклам сурталчилгаа нь бодит ахуй байдал, цаг үеэ үнэн зөвөөр үнэлэн дүгнэх, эрүүл оюун ухааныг хязгаарлан бүрхэгдүүлж байна.

Нөгөө талаар улс төр бохир байна. Тиймээс нөлөө бүхий ХМХ-үүдийн ард улс төрийн тодорхой нам, хэсэг бүлэг хүмүүс, томоохон бизнесменүүд байдаг бөгөөд сонин хэвлэл, телевизүүд тэдний удирдамж, зааварчилгаар үйл ажиллагаа явуулж, үзэл бодолд нь тааруулан нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж, захиалгаар бусдын нэр хүндийг гутаах, өөрсдийгөө магтуулах, сурталчлах зэвсэг болгосноор мэдээллийн тэнцвэрт байдал алдагдаж, сонины зай талбай, эфирийн үнэт цаг өш хонзон авах, тооцоо бодох, улс төрийн болон эдийн засгийн ашиг хонжоо хайх талбар болсон гэдгийг бид хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Товчоор хэлбэл, ХМХ-үүд ард түмний эрх ашиг, оюуны эрэлт хэрэгцээг бус, эрх мэдэлтэн, хөрөнгө мөнгөтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг, тэдний дуулгавартай зарц болон хувирсан. Нэг намын үзэл суртлын зэвсэг байсан сэтгүүл зүй өнөөдөр хэсэг хүмүүсийн үзэл бодлын индэр болон хувирч, үзэл суртлын

дайчин байлдагч байсан сэтгүүлчид “аялдан дагалдагчид” болон хувирсан нь нууц биш юм. Сэтгүүлч-уран бүтээлчдийн нийгмийн асуудал туйлын хүнд, цалин мөнгө, бусад хангамж дэндүү өчүүхэн байгаа нь захиалгат нийтлэл, нэвтрүүлэг, далд сурталчилгааны материал олширч, сэтгүүлчид хэд хэдэн хэсэгт хуваагдаж, хэн нэгний “сурталчилгааны хэрэгсэл” болон хувирахад нөлөөлж байна. Өнөөдөр сонины зай талбайн багагүй хувийг ийм зорилготой, өгөөж багатай, ач холбогдолгүй, албархуу нийтлэл эзэлж байхад үлдсэн хувийг реклам сурталчилгаагаар дүүргэснээр мэдээллийн тэнцвэрт байдал ихээхэн алдагдаж байна. Энэ бол манай сэтгүүл зүй олон нийтийг бодит мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх үндсэн үүргийг умартаж, ашиг хонжоо хайх зорилгын үүднээс хэн нэгэнд үйлчлэгч болон хувирч байгаагийн илрэл юм. Мөн манай сэтгүүл зүйн хөгжил төлөвшилд нөлөөлж буй олон хүчин зүйлийн, оршиж буй дутагдлын, учирч буй саад бэрхшээлийн нэгээхэн хэсэг ч хамгийн гол хүчин зүйл нь гэж хэлж болно. Сэтгүүл зүйн өнөөгийн нөхцөл байдал нь ийм байхад чөлөөт хэвлэл жинхэнэ утгаар нь оршин тогтнож, нийгэмд эрүүл саруул уур амьсгал бий болгоход нөлөөлдөг “дөрөв дэх засаглал”-ын үүргийг биелүүлэх, тэр тусмаа үүний тод илрэл болох нийгмийн хариуцлагатай сэтгүүл зүйг хөгжүүлэх боломжгүй гэж болно.

Эцэст нь нэгтгэн дүгнэхэд:

Нэгд, мэдээллийн нөлөө байр суурь нийгмийн амьдралд онцгой чухал болохын хирээр хэрэгслийн эзэмшил хяналт эрх мэдэл, хөрөнгө чинээ бүхий

явцуу цөөн тооны хүмүүсийн гарт төвлөрч байна.

Хоёрт, энэхүү явцуу хүрээнд үйлчлэх зорилготой, мэдээллийн технологийн хөгжилд тулгуурласан хэрэгслийн төвлөрөл нь ардчиллын үнэлэмжийн тулгуур болох эрх чөлөөтэй байх, өмчтэй байх, үзэл бодолтой байх зэрэг бие хүнийг дээдлэх үзэл баримтлалыг саармагжуулж байна.

Гуравт, хувь хүнийг дээдлэх үзлийн нөлөө байр суурь хумигдахын хирээр мэдээллийн хэрэгслийн нийгмийн өмнө хүлээсэн үүрэг болох үнэнийг мэдүүлэх, ардчиллын үнэлэмжийг төлөвшүүлэх, олон ургальч байдлыг хөхиүлэн дэмжих зэрэг хариуцлага, үйл ажиллагааны мөн чанар алдагдахад хүрээд байна.

Дөрөвт, хэрэв дээрх үйл явц цаашид гүнзгийрэн үргэлжилбэл ардчилал, парламентын тогтолцооны мөн чанар үгүй болж хөрөнгө мөнгө техник технологийн төвлөрөл бүхий цоо шинэ мэдээллийн дарангуйлал бий болох нь гарцаагүй.

Ишлэл

¹ 2009. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. УБ., 4 дэх тал.

² 2001. Ардчилсан сонгууль, хэвлэл мэдээлэл. Цуврал №2. УБ., 10 дахь тал.

³ Мөн тэнд, 55 дахь тал.

⁴ 2005. Свободная и ответственная пресса. М., с. 49.

⁵ Ср. Уэбстер. 2004. Теории информационного общества. М., с. 179.

⁶ Мөн тэнд, с. 223.

⁷ Kumar K. 1977. Holding the Middle Ground. L., p. 231.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Kumar K. 1977. Holding the Middle Ground. L.

2. Lasswell H. 1948. The Structure and Function of Communication in Society. N.-Y.

3. Mills W. 1956. The Power Elite. N.-Y.

4. 2005. Свободная и ответственная пресса. М.

5. Уэбстер. 2004. Теории информационного общества. М.

6. Фромм Э. 2002. Эрх чөлөөнөөс дайжихуй. УБ.

7. Болд – Эрдэнэ Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ.

8. Зулъякафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

Резюме

В настоящей статье авторы поднимают вопрос об истинном назначении независимой журналистики, о современном состоянии СМИ Монголии. Концентрация СМИ в руках кучки власть имеющих и бизнесменов, которые манипулируют ими для достижения своих корыстных целей, не может не вызывать обеспокоенности по поводу реальной свободы слова и печати.